

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв & Бизнесийн салбарын боловсон хүчин бэлтгэх төсөл

(Төсөл хэлбэрийн техникийн хамтын ажиллагаа)

Үндэслэл

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв нь Монгол улсын зах зээлийн эдийн засгийн хөгжил болон хоёр орны харилцан ойлголцлыг бэхжүүлэх зорилгоор “Япон орныг бодитоор таниулах хамтын ажиллагаа”-г хэрэгжүүлэх тулгуур төв болгон төслийн буцалтгүй тусламжийн хүрээнд 2002 онд байгуулсан билээ. Түүнээс хойш

1. Бизнесийн салбарын боловсон хүчний сургалт 2. Япон хэлний сургалт 3. Хоёр орны харилцан ойлголцлыг бэхжүүлэх гэсэн үйл ажиллагааны үндсэн гурван чиглэлээр төсөл хэлбэрийн техникийн хамтын ажиллагааг 2002 оноос эхлэн хэрэгжүүлж байна.

Агуулга

- Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийг байгуулах төсөл (Буцалтгүй тусламж: Ойролцоогоор 420 сая иен)
- Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн төсөл (Төсөл хэлбэрийн техникийн хамтын ажиллагаа: 2002 оны 1-р сар~2007 оны 1-р сар)
- Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн төсөл (Төсөл хэлбэрийн техникийн хамтын ажиллагаа: 2007 оны 1-р сар~2012 оны 1-р сар)
- Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн бизнесийн салбарын боловсон хүчин бэлтгэх төсөл (Төсөл хэлбэрийн техникийн хамтын ажиллагаа: 2012 оны 1-р сар~2015 оны 1-р сар)



Япон төв



Төв дээр зохион байгуулагдаж буй семинар

Үр дүн

Төв үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойших 10 жилийн хугацаанд жижиг дунд болон бичил бизнес эрхлэгчид, тэдгээрийн ажилтан албан хаагчид болох 5,300 хүний мэргэжил мэдлэгийг дээшлүүлэн, бизнесийн менежментээ сайжруулахад нь дэмжлэг үзүүлсэн. Мөн тус төвөөр үйлчлүүлэгчдийн тоо 2006 онд 500 мянгад хүрч байсан бол 2009 оны байдлаар 1 сая гараад байна.

Нөгөөтэйгүүр Монгол улсын эдийн засаг эрчимтэй өсч буй энэ цаг үед Монголын компаниуд бизнесээ улам өргөтгөж, цааш нь удирдан авч явахад илүү өндөр мэдлэг чадвар шаардагдаж байна. Мөн жижиг дунд үйлдвэрийн хөгжлийг дэмжих төрийн ажилтан, албан хаагчийг бэлтгэх

шаардлага шинээр гарч ирсэн тул төслийг үргэлжлүүлэхдээ бизнесийн салбарын боловсон хүчнийг илүү өргөн хүрээнд бэлтгэх чиглэлийг баримталж байна. Мөн япон хэлний сургалт болон хоёр орны харилцан ойлголцлыг бэхжүүлэх ажлын хүрээнд 2012 оны 4 дүгээр сараас эхлэн Япон Сан (Japan Foundation)-гаас шинэ сургалтыг явуулж эхэлсэн.

Тус төвийн захирлын албан тушаалыг 2012 оны 1 дүгээр сарыг дуустал япон хүн хашиж байсан бөгөөд 2012 оны 4 дүгээр сараас тус төвийн байгууламж болон удирдлагыг Монголын талд шилжүүлсэн ба одоо монгол захирлын удирдлага дор МУИС-ийн бие даасан нэгжийн статустайгаар үйл ажиллагаа явуулж байна.